



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 7 сарын 20 өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

Түр жагсаалт батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсад үнэт цаас гаргаж болох гадаадын үнэт цаас гаргагчийн бүртгүүлсэн арилжаа эрхлэх 26 байгууллагын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Монгол Улсын хадгаламжийн бичгийн суурь үнэт цаасны бүртгэл бүхий харьяалах 24 улсын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “Монголын үнэт цаасны бирж” ХХК /С.Даваасамбуу/-д тус тус үүрэг болгосугай:

1/ Тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компани үнэт цаасаа бүртгүүлэхэд тавигдах бүртгэлийн шаардлага, шалгуурыг шинэчлэн тогтоох, зарим тодорхой төрлийн шаардлагаас хөнгөлөх, чөлөөлөх чиглэлээр өөрийн дүрэм, журамд зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулах;

2/ Давхар бүртгэлтэй компанийн мэдээллийн ил тод байдлыг хангуулж, хөрөнгө оруулагчдад эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллах.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2017 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 151
тоот тогтоолын нэгдүгээр хавсралт



Монгол Улсад үнэт цаас гаргаж болох гадаадын үнэт цаас гаргагчийн бүртгүүлсэн
арилжаа эрхлэх байгууллагын жагсаалт

Д/д	Арилжаа эрхлэх байгууллагын нэр	Харьяалах улсын нэр
1	Австралийн үнэт цаасны бирж /Australian Securities Exchange/	Австрали Улс
2	Венийн хөрөнгийн бирж /Wiener Börse/	Австри Улс
3	Нью-Йоркийн хөрөнгийн бирж /The New York Stock Exchange/	Америкийн Нэгдсэн Улс
4	Наздак хөрөнгийн бирж /Nasdaq/	
5	Брюсселийн хөрөнгийн бирж /Euronext Brussels/	Бельги Улс
6	Солонгосын хөрөнгийн бирж /Korea Exchange/	Бүгд Найрамдах Солонгос Улс
7	Хонг Конгийн хөрөнгийн бирж /The Stock Exchange of Hong Kong/	БНХАУ-ын Тусгай захиргааны бүс Хонг Конг
8	Франкфуртын хөрөнгийн бирж /Deutsche Börse/	Герман Улс
9	Амстердамын хөрөнгийн бирж /Euronext Amsterdam/	Голланд Улс
10	Копенгагены хөрөнгийн бирж /Nasdaq Copenhagen/	Дани Улс
11	Тель-Авивын хөрөнгийн бирж /Tel-Aviv stock exchange/	Израиль Улс
12	Ирландын хөрөнгийн бирж /Irish stock exchange/	Ирланд Улс
13	Мадридын хөрөнгийн бирж /Bolsa de Madrid/	Испани Улс
14	Италийн хөрөнгийн бирж /Borsa Italiana/	Итали Улс
15	Лондонгийн хөрөнгийн бирж /The London Stock Exchange/	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
16	Шинэ Зеландын хөрөнгийн бирж /New Zealand Stock Exchange/	Шинэ Зеланд Улс
17	Стокгольмын хөрөнгийн бирж /Nasdaq Stockholm/	Швед Улс
18	Швейцарын хөрөнгийн бирж /SIX Swiss Exchange/	Швейцар Улс
19	Торонтогийн хөрөнгийн бирж /Toronto stock exchange/	Канад Улс
20	Торонтогийн венчур бирж /Toronto venture exchange/	
21	Ослогийн хөрөнгийн бирж /Oslo Bors/	Норвеги Улс
22	Лисабоны хөрөнгийн бирж /Euronext Lisbon/	Португали Улс
23	Сингапурын хөрөнгийн бирж /Singapore Exchange/	Сингапур Улс
24	Хельсинкийн хөрөнгийн бирж /Nasdaq Helsinki/	Финлянд Улс
25	Парисын хөрөнгийн бирж /Euronext Paris/	Франц Улс
26	Токиогийн хөрөнгийн бирж /Tokyo stock exchange/	Япон Улс

Монгол Улсын хадгаламжийн бичгийн суурь үнэт цаасны
бүртгэл бүхий харьяалах улсын жагсаалт

Д/д	Харьяалах улсын нэр
1	Австрали Улс
2	Австри Улс
3	Америкийн Нэгдсэн Улс
4	Бельги Улс
5	Бүгд Найрамдах Солонгос Улс
6	БНХАУ-ын Тусгай захиргааны бүс Хонг Конг
7	Герман Улс
8	Голланд Улс
9	Дани Улс
10	Израиль Улс
11	Ирланд Улс
12	Испани Улс
13	Итали Улс
14	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
15	Шинэ Зеланд Улс
16	Швед Улс
17	Швейцар Улс
18	Канад Улс
19	Норвеги Улс
20	Португали Улс
21	Сингапур Улс
22	Финлянд Улс
23	Франц Улс
24	Япон Улс